



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2022/61/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483034 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484030 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn	
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
Утас: 99177546		Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
Аудитор		С.Санчирмаа
Утас: 99282488		Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР ЗӨВЛӨХ
Б.БИЛЭГСАЙХАН ТАНАА**

2022.02.23 № 09
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

07020076

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	21.0	28.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	608.7	621.3
	Нийт хөрөнгийн дүн	629.8	649.9
	Нийт өр төлбөрийн дүн	0.2	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	629.5	0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	629.8	649.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	446.3	584.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	446.2	564.0
	Үйл ажиллагааны үр дүн	0.04	20.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	0.04	20.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	629.4	629.5
	Тайлант оны үр дүн	0.04	20.4
	Эцсийн үлдэгдэл	629.5	649.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	430.1	555.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	422.8	524.7
	Үйл ажиллагааны ЦМГ	7.3	31.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	7.3	31.1
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	420.1	516.8
	Урсгал зардал	420.1	516.8
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	420.1	516.8
	Улсын төсвөөс санхүүжих	420.1	516.8

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говь-Алтай аймгийн Прокурорын газар нь “Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих” үйл ажиллагааны чиглэлтэй.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 834.8 сая төгрөгийн 37 мэдээллийг ил тод байршуулахаас 717.8 сая төгрөгийн 33 мэдээллийг ил тод байршуулж, 47.3 сая төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй байсныг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах
- тушаал шийдвэртэй холбоотой зарцуулалт
- тээвэр шатахууны зарцуулалтыг тулган баталгаажуулсан эсэхийг үзэх нь зүйтэй.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 36.1 сая төгрөгийн газрыг орхигдуулан тоолсон нь тооллого комиссын гишүүд, тооцоо бодон хянасан нягтлан бодогчийн хариуцлагагүй байдалтай холбоотой тул дараагийн удаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 36.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн

7.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 4 компаниас 7.8 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

7.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

7.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 0.02 сая төгрөгөөр илүү, 0.1 сая төгрөгөөр дутуу зөрүү гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

7.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Аймгийн Прокурорын газар	1	1	0	0	1	0	0	0
	НИЙТ	1	1	0	0	1	0	0	0

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Аймгийн Прокурорын газар	3	36.6	1	36.5	0	0	1	0.1	0	0
	НИЙТ	3	36.6	1	36.5	0	0	1	0.1	0	0